Journal of Accounting Theory and Practice (Mar. 2018)
Vol. 2, No. 1, pp. 87-94

Аудитын нотлох зүйлийн чанарыг үнэлэх нь

Evaluate the Quality of Audit Evidence

Д. Лхагвасүрэн[1], Л. Хишигбаяр[2]

Хураангуй

Аливаа тайлангийн үр дүнг баталгаажуулах үндсэн хэрэгсэл нь нотлох зүйл байдаг. Өөрөөр хэлбэл тайлангийн чанарын түвшинг илэрхийлэх гол үзүүлэлт нь нотлох зүйлийн баталгаатай байдал юм. Гүйцэтгэлийн аудитын стандартад зааснаар нотлох баримт нь найдвартай, хангалттай, учир холбогдолтой байх гэсэн шалгууруудыг хангах ёстой. Иймээс гүйцэтгэлийн аудитын нотлох зүйл нь стандартын шалгууруудыг хангаж чадаж байгаа эсэх, аудитын нотлох зүйл цуглуулахад ямар бэрхшээл тулгарч байгааг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийсэн. Судалгаанд нийслэлийн аудитын газрын гүйцэтгэлийн албаны 15 мэргэжилтнийг хамруулан асуулгын аргаар судалгаа авахад тухайн мэргэжилтнүүдийн цуглуулсан нотлох зүйл нь стандартын найдвартай, хангалттай, учир холбогдолтой байх гэсэн шалгууруудыг дунд (5 оноонноос 2.85) түвшинд хангаж байна гэсэн үр дүн гарсан. Мөн гүйцэтгэлийн аудитын нотлох зүйлийг хаана цуглуулснаас үл хамааран нотлох зүйлийн чанар ижил түвшинд байна.

Түлхүүр үгс: гүйцэтгэлийн аудитын нотлох зүйл, нотлох зүйлийн шалгуур үзүүлэлтүүд

Abstract

The basic tool for verifying the audit report is evidence. In other words, evidence to be reliable increases audit reports more reliability. According to Performance Auditing Standards, this evidence should be reliable, sufficient and relevant. Thus, this study has been conducted to identify difficulties derived in collecting audit evidence. And to determine whether to provide audit standards requirements for performance audit evidence. Auditors belonging to State Audit Organization have been surveyed in this study. The outcome of the qualitative characteristics: reliability, sufficiency, and relevance show less average results. This result shows the medium quality of performance audit reporting (2.85 scores from 5). In addition, it concluded quality of evidence should be at the same level, irrespective of where the performance audit evidence is collected.

Keywords: performance audit evidence, criteria of evidence

[1] МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш, МНБ
E-mail: dlkhagva@num.edu.mn
[2] МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш, МНБ, ТИНБ
E-mail: khishigbayar@num.edu.mn

1. Нотлох зүйл, түүний шалгуур үзүүлэлтүүд

Аудитын нотлох зүйл гэдэг нь аудитын зорилгыг биелүүлэхийн тулд аудиторын цуглуулсан чухал баримт материал бөгөөд эдгээр нь аудитын асуултанд хариулт өгөх, тогтоосон таамаглалыг батлах боломжийг олгодог. Аудитын нотолгоо нь аудиторын ажлын тайлангийн үр дүнг дэмжих хэрэгсэл болдог. Гүйцэтгэлийн аудитын хувьд нотлох зүйл нь шалгагдаж байгаа байгууллагын удирдлага, албан хаагчид нөөцийг хэрхэн үр дүнтэй, үр ашигтай, арвич хямгач ашиглаж байгаа, зарчим, бодлого, стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж мөрдсөн эсэхийг дүгнэх, шалгалтын дүн найдвартай бөгөөд баталгаатай гэдгийг хөндлөнгийн этгээдэд илтгэн харуулах зорилгоор ашигласан баримт мэдээлэл юм. Гүйцэтгэлийн аудитын стандартад зааснаар нотолгоо нь хангалттай, найдвартай, учир холбогдолтой байх гэсэн үндсэн 3 шалгуурыг хангах ёстой.

Хангалтай: Тооны хувьд хэмжиж болохуйц, чанарын хувьд итгэл төрүүлэхүйц, дүгнэлт зөвлөмжид ердийн хүнийг итгүүлж чадахуйц байх ёстой.

Найдвартай: Бодит баримтанд нийцсэн хүчин төгөлдөр, хэд хэдэн эх үүсвэрээр баталгаажсан, аман гэхээс илүү баримтат, фото эх хувь байх.

Учир холбогдолтой: Аудитын зорилт, шалгуур учир шалтгаан, утга агуулгын хувьд холбоотой, нотлох зүйлийн зориулалт эх сурвалж хамрах хүрээг тэмдэглэсэн байх.

Аудитын зорилгоос хамааран нотлох зүйлийг биет, аман, баримтат зэрэг хэлбэрээр цуглуулж болно. Мөн санал асуулга, судалгаа шинжилгээ шууд ажиглалт хийх замаар мэдээллийг цуглуулдаг.

Аман нотлох зүйл нь асуулга, ярилцлагад хариулт болгож өгсөн мэдэгдлийн хэлбэртэй байж болно. Энэ аргаар шалгагдагч байгууллагаас тэр бүр олж авах боломжгүй чухал сэжүүр гарган авч болно. Аман нотлох баримтыг тухайн салбарын мэргэжлийн хүн, зөвлөхүүдээс авч болно. Ярилцлага өгсөн хүнээс бичгээр баталгаа гаргуулж авах, ижил сэжүүр гаргаж өгсөн эх үүсвэрийн аль жинтэйг нь ашиглах хэрэгтэй. Энд шинжээчээс мэргэжлийн ур чадвар шаардахаас гадна тухайн харилцаж байгаа хүний биеэ хэрхэн авч явж байгаа, асуултанд хариулж байгаа байдалд дүгнэлт өгөх боломжийг олгодог.

Шалгагдаж буй объектыг ажиглах байдлаар биет нотолгоог олж авна. Энэ нь фото зураг, диаграмм, видео бичлэг, бусад хэлбэртэй байдаг. Биет болон цахим хэлбэртэй баримтат нотлох зүйл нь нотолгооны нийтлэг хэлбэр юм. Баримтат нотлох зүйлийг шалгагдагч байгууллагын дотроос болон гаднаас олж авч болно. Байгууллагын гаднаас авах нотолгоо нь хүлээн авсан баримт бичиг, захидал, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, гэрээ, хөндлөнгийн болон дотоод аудитын тайлан зэрэг юм. Дотоод нотлох зүйл нь шалгагдагч байгууллагын дотооддоо боловсруулсан албан тоот, захидал, ажлын байрны тодорхойлолт, няглан бодох бүртгэлийн болон дотоод хэрэгцээний тайлан, дотоод дүрэм, журам зэрэг юм. Баримт бичгийг боловсруулсан буюу баталсан хүний албан тушаал, мэдлэг, туршлагыг үнэлсэн байх шаардлагатай.

Дүн шинжилгээний нотлох зүйл нь мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ ба нотолгооноос урган гарна. Дүн шинжилгээ

гэдэгт шалгагдагч байгууллага болон холбогдох бусад эх үүсвэрээс авсан мэдээлэлд хийсэн тооцоолол, түүний хувь хэмжээ, хандлага дүр төрхөд хийсэн дүн шинжилгээ багтана.

Нотлох зүйлийг ямар эх үүсвэрээс, ямар хэлбэрээр олж авснаас хамаарч нотлох зүйл нь дараах онцлогтой байдаг.

Гадаад эх үүсвэрээс авсан нотлох зүйл	Гадаад эх үүсвэрээс олж авсан нотлох зүйл нь (тухайлбал, гуравдагч талаас авсан тулган баталгаажуулалт) дотоодоос буюу байгууллагын гаргасан баримт бичгээс олж авсан нотлох зүйлийг бодвол илүү үнэмшилтэй найдвартай байдаг.
Аудиторын шууд олж авсан нотлох зүйл	Аудитор өөрөө шууд олж авсан нотлох зүйл нь бусдаас шууд олж авсан нотлох зүйлээс илүү найдвартай
Байгууллагаас авсан нотлох зүйл	Хэрэв байгууллагын дотоод хяналтын систем үр ашигтай ажилладаг бол уг байгууллагын бүртгэлээс олж авсан нотлох зүйл нь илтгэх зэрэг өндөртэй байдаг.
Бичгэн нотлох зүйл	Бичгэн буюу баримт хэлбэртэй нотлох баримт нь аман нотлох зүйлээс илүү илтгэх зэрэг өндөртэй байдаг.
Эх хувилбар	Баримтын эх хувь нь түүний хуулбараас илүү найдвартай.

Ямар ч хэлбэрийн нотлох зүйлийг цуглуулахдаа тухайн мэдээллийн эх үүсвэрийг бүрэн бичиж тэмдэглэсэн байх шаардлагатай.

Нотлох зүйлийг цуглуулж зохих ёсоор баримтжуулах нь дараах ач холбогдолтой

- Шалгалтын дүгнэлт тайланд дэмжлэг баталгаа болно.
- Шалгалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.
- Тайлан бэлтгэх, шалгагдагч байгууллага болон бусад газраас тавьсан асуулгад хариулт өгөх мэдээллийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэнэ.
- Шинжээч стандарын дагуу ажилласан гэдгийн нотлох зүйл болно.
- Даатгасан ажил хангалттай хийгдсэн эсэхийг нягтлахад тус болно.

2. Судлагдсан байдал

Гүйцэтгэлийн аудитыг төрийн өмчийн байгууллагуудад өргөн хэрэглэдэг. Гүйцэтгэлийн аудитын ач холбогдол, үр дагавар, чанар зэргийг судалсан судалгааны ажлуудаас дурьдвал:

Reichborn-Kjennerud (2013) нь Норвеги улсын 353 төрийн албан хаагчдаас төрийн аудитын үйл ажилагааны талаар судалгаа авахад төрийн аудитын үйл ажиллагаа нь хэрэгтэй, ач холбогдолтой гэсэн үр дүн гарсан.

Daujotaitė нар (2017) Литвийн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын талаарх мэдээлэлд үндэслэн судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд төрийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээнд нөлөөлөх хүчин зүйлс болон нөөцийг ашиглан төрийн байгууллагын үйл ажиллагааны загвар боловсруулсан. Загварыг ашиглан зардлыг хэмнэх боломжтой гэж үзсэн.

Daujotaitė нар (2008) гүйцэтгэлийн аудит нь төрийн үйл ажиллагаатай зэрэгцэн хөгжиж ирсэн. Удирдлагын шинэчлэл болон гүйцэтгэлийн аудитын хөгжил нь онолын хувьд ялгаатай чиглэлээр явагддаг боловч удирдлагын шинэчлэл нь аудитын шинэ туршлага эсвэл аудитын шинэ туршлага нь удирдлагад шинэчлэлийг үүсгэж байдаг.

Өөрөөр хэлбэл шинэ сайн удирдлага аудитыг хөгжүүлж болно. Аудитын хөгжил нь байгууллагын засаглалын үйл ажиллагаатай холбогддог. Гүйцэтгэлийн аудитын хөгжил, үйл явц нь байгууллагын удирдлага, гүйцэтгэлийн аудит хийх загваруудаас хамаарна.

Баярсайхан (2013) төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллага нь төрийн аудитын бүрэн эрхэд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх ёстой. Харин манай улсын Үндэсний Аудитын Газар (ҮАГ) нь бүхий л талаараа төрийн эрх барих дээд байгууллагатай ямар нэгэн сэжмээр холбоотой байна гэж үзсэн. Иймээс ҮАГ-ын үйл ажиллагааг үндсэн хуулиар хуульчлах, баримт нотлох зүйлийг нуун дарагдуулах, гаргаж өгөхөөс зайлсхийсэн тохиолдолд ногдох шийтгэврийг өсгөх, төрийн аудитыг хийж гүйцэтгэх мэргэжилтнүүдийг чадваржуулах нь зүйтэй гэж үзжээ.

Сэргэлэн (2014) гүйцэтгэлийн аудитын чанарт *нэгдүгээрт*, хууль тогтоомж, холбогдох дүрэм журам; *хоёрдугаарт*, боловсон хүчин; *гуравдугаарт*, чанарын хяналт, чанарын баталгаажуулалт гэсэн хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзсэн. Иймээс гүйцэтгэлийн аудитын чанарыг сайжруулах, гүйцэтгэлийн аудитын тайлангийн загвар гаргах, хууль эрх зүйг сайжруулах нь зүйтэй гэж үзжээ.

Ганцэцэг (2016) гүйцэтгэлийн аудит нь зохих агуулгын хүрээнд хийгдэхгүй, баримтын шалгалт хэлбэртэй байна. Үүнд гүйцэтгэлийн аудитыг хийх тодорхой аргачлал, арга зүйг баталгаажуулан гаргаагүй, зохион байгуулалтын хувьд дотоод аудитын албанд санхүүгийн хяналтыг нэгтгэсэн нь нөлөөлж байна гэж дүгнэжээ.

3. Гүйцэтгэлийн аудитын нотлох зүйл цуглуулах өнөөгийн байдал

Баримт бичиг судлах аргаар 2016-2017 онд явуулсан гүйцэтгэлийн 8 аудитын ажлын баримтыг түүвэрлэн авч үзэхэд нотлох зүйл цуглуулахад аман болон баримтат хэлбэрийг түлхүү ашигладаг бол биет болон дүн шинжилгээний хэлбэрийг бага ашиглажээ.

Нийслэлийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын албаны мэргэжилтнүүд нотлох зүйл цуглуулахад доорх хүндрэлтэй асуудлууд тулгарч байна гэж хариулсан. Тухайлбал:

- Биет нотлох зүйл цуглуулахад хугацааны хувьд өнгөрсөн байдаг нь тухайн үед хэрхэн хэрэгжсэнийг нотлоход хүндрэлтэй, шалгагдагч байгууллагын өөрийн цуглуулсан фото зураг болон график, диаграммд мэргэжлийн ур чадварыг ашиглаж дүгнэлт гаргах хэрэгтэй болдог,
- Ихэнх шалгагдагч байгууллага нь зорилго, зорилтоо бүрэн тодорхойлоогүй, урт хугацааны төлөвлөгөө боловсруулаагүй нь хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэхэд харьцуулалтын шинжилгээ хийх боломжгүй болгодог (Тухайлбал, Нийтлэг Үйлчилгээний Улаанбаатар Нэгтгэл ОНӨААТҮГ гэх мэт),
- Баримт цуглуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон хоорондоо мэдээлэл солилцох тогтолцоо сул тул хэнд хандаж мэдээлэл цуглуулах нь тодорхойгүй байдаг,
- Нотлох баримт нь архивт бүрэн хадгалагдаагүй байдаг,
- Байгууллагын удирдлага тогтвор

суурьшилгүй ажилладаг нь гарсан зөрчилд хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй болох эрсдлийг үүсгэдэг (Тухайлбал, 2014 онд Төрийн байгууллагуудын бүтэц орон тоонд аудит хийхэд Усны барилга байгууламж, Хот тохижилтын газар, Зам засвар арчлалт ХХК-ууд нэгдэж "НҮУБН" ОНӨААТҮГ-ыг байгуулснаар дээрх байгууллагуудын талаар мэдээлэл өгөх хүн байхгүй байсан гэх мэт).

4. Судалгааны хэсэг

Гүйцэтгэлийн аудитын нотлох зүйл нь хангалттай байх, найдвартай байх, учир холбогдолтой байх гэсэн стандартын шаардлагуудад нийцдэгэсэхийгтодруулах; аудитын нотлох зүйл цуглуулахад үүсдэг бэрхшээлийг илрүүлэхийн тулд НАГ-ын гүйцэтгэлийн албаны аудитор, шинжээч нараас судалгаа авсан.

Нийт 10 асуулт бүхий асуулга боловсруулан нийслэлийн аудитын газрын 15 шинжээчээс авсан болно. Сүүлийн 4 асуулт нь аудитын нотлох зүйлийн хангалттай байх, найдвартай байх, учир холбогдолтой байх гэсэн шаардлагыг илрүүлэхэд чиглэсэн.

Зураг 1. Ажилчдын ажилласан жил



Ажилласан жилийн хувьд авч үзэхэд 73 хувь нь 0-5 орчим жил аудитын салбарт ажиллаж буй залуу боловсон хүчин, 27% нь 5-20 жил ажиллаж байгаа туршлагатай боловсон хүчин байна. Ажиллах хүчний дийлэнх хувийг залуу ажиллагсад эзэлж байгаа нь аудитын сургалтыг тасралтгүй явуулж байх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Судалгаанд хамрагдагсдын үндсэн мэргэжлийг харахад нягтлан бодогч 6, эдийн засагч 6, инженер 1, экологич 1, эрх зүйч 1 байна.

Зураг 2. Гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаанд нотлох зүйл цуглуулах байдал



Графикаас харахад аудиторууд обьект дээрээс нотлох зүйлийг сайн цуглуулдаг байна.

Нотлох зүйлийг ямар хэлбэрээр илүүтэй цуглуулдаг болохыг мэдэхийн тулд олон сонголтот хувилбартай асуулга боловсруулсан.

Хүснэгт 1. Нотлох зүйл цуглуулах хэлбэр

Нотлох зүйл авах хэлбэрүүд	Давхацсан тоогоор	Хувь
Ярилцлага	11	73%
Баримт бичих хянах	13	87%
Харьцуулалт	9	60%
Нийт дүн	15	

Нийт судалгаанд хамрагдсан 15 хүний 87% нь баримт бичиг хянах байдлаар нотлох зүйл цуглуулдаг гэж хариулжээ. Мөн ярилцлага, асуулгын аргыг хэрэглэдэг байна.

Нотлох зүйл цуглуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ гэсэн нээлттэй асуулт тавихад шалгагдагч байгууллагаас ирж буй тоо мэдээ баримт бодитой бус, төлөвлөлтийн үе шатны хугацаа богино байдаг, шалгагдагч байгууллага баримт материал хугацаандаа гаргаж ирүүлдэггүй гэж хариулсан байна.

Ерөнхий 7 асуултын дараа үндсэн 4 асуултуудыг асуусан. Ингэхдээ хангалттай байх, найдвартай байх, учир холбогдолтой байх гэсэн шалгууруудыг нотлох зүйлдээ тусгаж чаддаг эсэхийг илрүүлэхийн тулд шалгуур бүрт харгалзах асуултуудыг боловсруулсан. Үүнд:

Нотлох зүйлийн шаардлага	Асуултууд
Хангалттай байх	- Нотлох зүйл хангалттай бус боловч аудитын хугацаа болон бусад хүчин зүйлээс хамаарч аудитын тайланд дүгнэлтээ тусгаж байсан уу?
Найдвартай байх	- Таны хувьд ямар эх үүсвэрээс авсан мэдээлэл илүү сайн нотлох зүйл болж чадах вэ? - Аудитын тайлан, дүгнэлт гарсны дараа өөрийн цуглуулсан нотлох зүйлдээ эргэлзэж байсан тохиолдол байгаа юу?
Учир холбогдолтой байх	- Аудитын дүгнэлтэнд төдий л ач холбогдолтой бус нотлох зүйл оруулж байсан уу?

Асуулт бүрт 4 сонголтот хариулт өгсөн бөгөөд хариулт бүрт харгалзах 1-4 оноотой. Эерэг хариултанд 4 оноо, хамгийн муу хариултанд 1 оноо өгсөн.

3 үндсэн шалгууруудынхаа дэлгэрэнгүй статистикийг гаргаж үзэхэд дундаж нь 2.85 байгаа нь нотлох зүйл цуглуулалт дунд түвшинд байна гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, аудитын нотлох зүйл стандартын дагуух шалгууруудыг 71% хангадаг гэсэн үг юм. Шалгуур бүрийн хувьд 2.5-2.7 гэсэн онооны хооронд хэлбэлзэлтэй байгаа нь аудитын цуглуулж буй нотлох зүйл 3 шалгуурыг ижилхэн дунд түвшинд хангадаг гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 3-аас харахад гүйцэтгэлийн аудитын нотлох зүйлийг урьдчилсан судалгаа эсвэл обьект дээр цуглуулсан эсэхээс үл хамааран нотлох зүйлийн чанар ижил түвшинд байна.

Дүгнэлт

Асуулгын судалгаанд хамрагдагсад баримт бичиг шалгах, ярилцлага, асуулгын аргаар нотлох зүйл цуглуулдаг бөгөөд хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь баримт бичгийг судлах арга байна. Гүйцэтгэлийн аудитын явцад шалгагдагч байгууллагаас ирж буй тоо мэдээ баримт бодитой бус, төлөвлөлтийн үе шатны хугацаа богино байдаг, баримт материал хугацаандаа гаргаж ирүүлдэггүй гэсэн бэрхшээлүүд

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн аудитын шалгууруудын дэлгэрэнгүй статистик

Үзүүлэлт	Түүврийн тоо	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга	Стандарт хазайлт
Хангалттай байх	15	2.00	4.00	2.7333	0.7037
Учир холбогдолтой байх	15	1.00	4.00	2.5333	1.1255
Найдвартай байх	15	1.50	4.00	2.6667	0.7238
Нотлох зүйлийн шалгуур	**15**	**2.64**	**3.42**	**2.8547**	**0.2431**

Хүснэгт 3. Аль үе шатанд нотлох зүйл цуглуулах нь илүү ач холбогдолтой байгааг авч үзвэл:

Нотлох зүйл цуглуулах байдал		Хангалттай	Найдвартай	Учир холбогдолтой	Ерөнхий дүн
Урьдчилсан судалгааны үед	Дундаж утга	3.3333	2.1667	3.0000	2.8667
	Түүврийн тоо	3	3	3	3
	Стандарт хазайлт	1.1547	0.5774	1.7321	0.2639
Объект дээр	Дундаж утга	2.5833	2.7917	2.4167	2.8517
	Түүврийн тоо	12	12	12	12
	Стандарт хазайлт	0.5149	0.7217	0.9962	0.2501

нотлох зүйл цуглуулахад тулгардаг байна.

Нотлох зүйлийн шалгууруудад харгалзах асуулт боловсруулан судалгаанд хамрагдагсдаас асуухад шалгууруудын дундаж үзүүлэлт 2.85 (нийт 4 онооноос) гэсэн үр дүн гарсан. Энэ нь гүйцэтгэлийн аудитын явцад шинжээчдийн цуглуулсан нотлох зүйлийн чанар дундаж түвшинд буюу стандартын дагуух шалгууруудыг 71%-тай хангаж байна.

Хангалттай байх, найдвартай байх, учир холбогдолтой байх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд 2.5-2.7 хооронд оноо авсан нь шалгуур үзүүлэлтүүдийн хоорондох хэлбэлзэл бага байна. Мөн нэмэлт шинжилгээ хийж үзэхэд аудитын нотлох зүйлийг урьдчилсан судалгааны үед эсвэл обьект дээр цуглуулсан эсэхээс үл хамааран нотлох зүйлийн чанар ижил түвшинд байна.

Нотлох зүйл цуглуулах арга зүйг сайжруулахад дараах зүйлс шаардлагатай гэж үзэж байна.

1. Төрийн байгууллагууд үйл ажиллагааны зорилго, зорилтоо зөв тодорхойлох, урт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах,
2. Төлөвлөлтийн үе шатанд байгууллагын үйл ажиллагааны талаарх судалгааг сайн хийж ямар нотлох баримт шаардлагатайг урьдчилан тодорхойлсон байх,
3. Нотлох зүйлээ цуглуулах эх үүсвэрээ урьдчилан сайтар тодорхойлох,
4. Цуглуулсан нотлох зүйлийн үнэн зөв, найдвартайг шалгагдаж буй байгууллагаар баталгаажуулан мэдээлэл өгсөн этгээдийн мэдээллийг бүрэн тэмдэглэх,
5. Шалгагдагч байгууллагаас авсан тоо, мэдээ, тайланд дүгнэлт хийн аудитын байгууллага архивтаа үнэн зөв мэдээ, тоон судалгаатай болох.

Ашигласан материал

1. Daujotaitė, D., Adomavičiūtė, D. (2017). The Role and Impact of Performance Audit in Public Governance, *Empirical Studies on Economics of Innovation, Public Economics and Management*, 6, 29-44
2. Daujotaitė, D., Maerinskien, I. (2008). Development of Performance Audit in Public Sector, *5th International Scientific Conference Business and Management*
3. Reichborn-Kjennerud, K. (2013). Political Accountability and Performance Audit: The Case of the Auditor General in Norway, *Public Administration*, 91(3), 680-695
4. Батбаяр, Б. (2013). Гүйцэтгэлийн аудит, *Төрийн захиргаа*, 27, 64-69
5. Баярсайхан, Л. (2013). Монгол улсын төрийн аудитын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг боловсронгуй болгох асуудал
6. Гантулга, Г. (2012). Аудит
7. Ганцэцэг, Г. (2016). Төсвийн зарцуулалтанд хийх гүйцэтгэлийн аудит
8. Гүйцэтгэлийн аудитын гарын авлага (2006)
9. Гүйцэтгэлийн аудитын удирдамж 3000-3100 (2015)
10. Гүйцэтгэлийн аудитын стандарт (2001)
11. МУ-ын төрийн хяналт шалгалтын стандарт (2012)
12. Сэргэлэн, Б. (2014). Төрийн аудитын чанарт хийсэн судалгаа
13. Төрийн аудитын тухай хууль (2003)
14. Төрийн хяналт шалгалтын байгууллагын ажилтны гарын авлага (2003)
15. Төрийн хяналт шалгалтын стандартыг хэрэглэх аргачилсан зөвлөмж (2003)